



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 1/204

Улаанбаатар хот

**Төрийн захиргааны албан тушаалын
тодорхойлолтыг батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 111 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрсний дагуу Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын орлогч даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Захиргаа санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Захиргаа санхүүгийн хэлтсийн ахлах, хүний нөөцийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн Өмч хувьчлал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Захиргаа санхүүгийн хэлтсийн Дотоод хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Программ хангамж хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Дотоод ажил, тогтоол захирамжийн биелэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Шуурхай ажлын биелэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр, Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн бүртгэл хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 15 дугаар, Мэдээллийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 16 дугаар, Өмч хувьчлал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 17 дугаар, Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн Өмчийн төлөөлөл хариуцсан мэргэжилтний

115050000564

албан тушаалын тодорхойлолтыг 18 дугаар, Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 19 дүгээр, Хуулийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 20 дугаар, Хөрөнгийн бүртгэл, орлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 21 дүгээр, Байр ашиглалт, түрээс хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 22 дугаар, Хяналт шалгалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 23 дугаар, Өмчийн ашиглалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 24 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг албан тушаалтнуудад танилцуулан мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ